

**ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2022**

Агуулга

БИДНИЙ ТУХАЙ

Өмнөх үг	4
Группийн тухай	6
2022 оны онцлох үзүүлэлтүүд	7

» 4-7

АЛСЫН ХАРАА

Тогтвортой хөгжлийн стратеги	9
Материаллаг байдал ба оролцогч талууд	10
Оролцогч талуудын харилцаа	11

» 9-11

БАЙГАЛЬ ОРЧИН

Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хий	13
Эрчим хүчний менежмент	14
Тээвэр	15
Усны менежмент	16
Хог хаягдлын менежмент	17
Биологийн олон янз байдал	19

» 13-19

НИЙГЭМ

Ажиллах орчин ба ажилтнууд	21
Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр	22
Сургалт, хөгжил, чадавх бэхжүүлэх	24
Сайн дурын үйл ажиллагааг дэмжих	27
Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй	28
Иргэд, олон нийт, нийгэмд чиглэсэн арга хэмжээ	29
Нийгмийн хариуцлага ба хамтын ажиллагаа	33

» 21-36

ЗАСАГЛАЛ

Бүтэц тогтолцоо	38
БОНЗ-ын тогтолцоо	39

» 38-39

ЭДИЙН ЗАСАГ

Эдийн засагт оруулсан хувь нэмэр	41
----------------------------------	----

» 41

БИДНИЙ ТУХАЙ

Өмнөх үг	4
Группийн тухай	6
2022 оны онцлох үзүүлэлтүүд	7



Өмнөх үг

М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниуд Монгол Улсын “Алсын хараа 2050” болон бусад урт хугацааны бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, урт хугацаандаа “Net-Zero” компани болох зорилттойгоор бизнесийн үйл ажиллагаагаа НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудтай уялдуулан байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Бид Группийн бодлого, журмуудыг БОНЗ-ын зарчимтай уялдуулж, Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогоо Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд шинэчлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, уян хатан ажиллах орчныг бүрдүүлэх зорилтынхоо хүрээнд бид ажилтнууддаа ажлын цагийг сонгон ажиллах, боломжтой ажлын байруудад зайнаас ажиллах боломжийг олгодог. Түүнчлэн тайлант онд Юнител Групп болон М-Си-Эс Кока-Кола компаниуд бүсийн оффисуудыг байгуулсан бол “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого”-тойгоо уялдуулан байгууллагын дэргэдэх хоёр цэцэрлэгийг байгууллаа.

Тайлант онд бид байгалийн үр өгөөжийг үнэлж, зөв зохистой ашиглах, хүлэмжийн хийн ялгарлыг тодорхойлон бууруулах, ажилтнуудаа дэмжиж, эрүүл, тэгш хүртээмжтэй ажиллах орчныг бүрдүүлэх, нийгмийн хөгжлийг дэмжих, нээлттэй, ил тод засаглалыг сайжруулах зэргийг БОНЗ-ын голлох чиглэлүүд хэмээн тодорхойлсон юм. Улмаар байгаль орчин, нийгэмдээ ээлтэй үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхлэх хэв маягийг Группийн хэмжээнд бэхжүүлж байна.

М-Си-Эс Групп байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөө тооцохоор зургаан компанидаа олон улсын арга зүйн дагуу хүлэмжийн хийн тооллогыг хийсэн ба тайлант онд ялгарлаа 5.8 мян.тн CO₂-экваар бууруулжээ. Мөн эрчим хүчний хэмнэлттэй технологи ашиглан 1,409 МВт.ц хэмнэлтийг бий болгосноос гадна бизнесийн үйл ажиллагаандаа цэвэр эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглан 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 22.7 хувиар бууруулах Монгол Улсын зорилтод тодорхой хувь нэмэр оруулж байгаа юм.

Түүнчлэн хог хаягдлыг дахин боловсруулах аяны хүрээнд савлагаа, цахим хог хаягдлыг цуглуулах кампанит ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна. Тодруулбал, М-Си-Эс Кока-Кола компани 2030 он гэхэд ундааны бүх саваа дахин боловсруулдаг болох зорилт тавин “Хуванцрын хаягдалгүй дэлхий” кампанит ажлыг эхлүүлж, тайлант онд борлуулсан ПЭТ савлагаатай бүтээгдэхүүнийхээ савын 61 хувийг буцаан цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгчээ.

Дээрх болон тогтвортой хөгжилд нийцсэн бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэл, ажилтнууд болон харилцагч, ханган нийлүүлэгчид зэрэг оролцогч талуудад чиглэсэн бодлого, нийгмийн хариуцлага зэрэг ажлуудаа энэхүү тайланд тусгахыг зорилоо. Тогтвортой ирээдүйг бүтээлцэж, нийгэм, байгаль орчиндоо авснаасаа багагүйг буцааж өгдөг “Net-Zero” компани болох бидний зорилго, явцтай танилцахыг урьж байна.



Хүндэтгэсэн,

М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Л. Гантөмөр



Группийн тухай

М-Си-Эс Групп нь эрчим хүч, дэд бүтэц, инженеринг, мэдээлэл, харилцаа холбоо, барилга, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбар, эрүүл мэнд зэрэг салбарт ажилласан он жилүүддээ тогтсон байгууллагын соёлтой, төлөвшсөн боловсон хүчинтэй, түүчээлэх чадвартай Групп болон тэлжээ.

Бид нийгэм, улс орныхоо өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, дэлхийн стандарт, дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлж, олон улсын компани болон хөрөнгө оруулагчидтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоог нэвтрүүлэн, урт хугацаанд тогтвортой хөгжлийн зорилгуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.

БАЙГАЛЬ ОРЧИН

- Хүлэмжийн хий

676 МЯН.ТН CO₂-ЭКВ
түвшин 1 ба 2-ын хүрээнд хүлэмжийн хий ялгаруулсан



5.8 МЯН.ТН CO₂-ЭКВ
хүлэмжийн хийг тооцооллоор бууруулсан

- Эрчим хүч

1,409 МВТ.Ц
эрчим хүчний хэмнэлтийг бий болгосон



2,418 МВТ.Ц
сэргээгдэх эрчим хүчээр цахилгаан үйлдвэрлэсэн

- Ус


445 МЯН.ТН
усыг зориулалтын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн



45 МЯН.ТН
саарал усыг цэвэрлэгээ, усалгаанд дахин ашигласан

НИЙГЭМ

- Ажилтан



- 41% – нийт эмэгтэй ажилтан
- 45% – эмэгтэй менежер
- 40% – удирдах түвшний эмэгтэй менежер

7 бүсийн оффис байгуулсан

2 нийт 150 орчим хүүхдийн багтаамжтай байгууллагын дэргэдэх 2 цэцэрлэг байгуулсан

77,891 **ажилтан** ХАБ-ын сургалтад хамрагдсан



21 орон нутгийн хөгжлийг дэмжих **төсөл хөтөлбөр**

ЭДИЙН ЗАСАГ

- Сүүлийн таван жилийн татвар, шимтгэлийн нийлбэр дүн

2.5 **ИХ НАЯД**

2022 онд



Нийгмийн хариуцлагын хүрээнд нийт **32 тэрбум төгрөг** зарцуулж, 93 төсөл хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

ЗАСАГЛАЛ

35 БОНЗ хариуцсан ажилтан

27 нийцэл хариуцсан ажилтан

16 эрсдэл хариуцсан ажилтан

50 ХАБ-ын ажилтан

АЛСЫН ХАРАА БА ЗОРИЛТ

Тогтвортой хөгжлийн стратеги	9
Материаллаг байдал ба оролцогч талууд	10
Оролцогч талуудын харилцаа	11

Тогтвортой хөгжлийн стратеги

Бизнесийн ёс зүйтэй, ил тод, нээлттэй, хариуцлагатай засаглалтай

- Бизнесийн ёс зүйтэй, нээлттэй засаглал
- Эрсдэл, нийцлийн удирдлага
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа, хамтын оролцоотой үйл ажиллагаа эрхлэх



Ажилтнуудаа дэмжих, эрүүл хүртээмжтэй орчныг бүрдүүлэх

- Хүний эрхийг дээдэлж, олон янзат байдал, хүртээмжтэй байдлыг бий болгох
- Сургалт, хөгжил, чадавх бэхжүүлэх
- Сайн дурын ажиллагааг дэмжиж, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах
- Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх



Байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй

- Хүлэмжийн хийн ялгарлаа тооцох, бууруулах
- Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох
- Байгалийн нөөцийн зохистой хэрэглээ, биологийн олон янз байдлыг хамгаалах
- Хог хаягдлын зөв, зохистой менежмент, хэрэглээг бууруулах



Материаллаг байдал ба оролцогч талууд

Оролцогч талууд

Хувьцаа эзэмшигчид | Хөрөнгө оруулагчид | Ажилтнууд | Бэлтгэн нийлүүлэгчид | Туслан гүйцэтгэгчид | Хэрэглэгчид | Төрийн байгууллага | Төрийн бус байгууллага | Иргэд ба олон нийт

Эрүүл, аюулгүй ажиллах орчин

Ажлын байрны ёс зүй, эрх тэгш байдлыг хангах

Цэвэр технологийн эх үүсвэрийг дэмжих

Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг бий болгох

Ажлын байрны ёс зүй, эрх тэгш байдлыг хангах

Хүний эрхийг дээдлэх, олон янзат байдлыг хүлээн зөвшөөрөх

Хууль, дүрэм журамд нийцэх

БОНЗ-ын нээлттэй тайлагнал

Санхүүгийн тайлагнал

Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлээс сэргийлэх

Хүлэмжийн хийн ялгарлыг тооцох, бууруулах алхмууд

Ёс зүйтэй, шударга бизнес

Дижитал, цахим шилжилт

Ил тод, нээлттэй засаглалтай байх

Орон нутгийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа, туслалцаа дэмжлэг

Нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах

Тогтвортой хөгжлийн зарчмыг стратегид тусгах

Татвар төлөлт

Байгалийн нөөцийн зохистой хэрэглээ, сөрөг нөлөөллийг бууруулах

БОНЗ-ын чиглэл

Байгаль орчин

Нийгэм

Засаглал

Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах

Хүмүүн капитал ба хөдөлмөрийн харилцаа

БОНЗ-ын засаглал, менежментийн тогтолцоо

Эрчим хүчний менежмент

Хүний эрх, олон янзат, хүртээмжтэй байдал

Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого

Байгалийн нөөцийн менежмент ба биологийн олон янз байдал

Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчин

Эрсдэл ба нийцлийн менежмент

Хог хаягдлын менежмент

Нийгмийн хөгжил, оролцоо

Ил тод байдал ба тайлагнал

Оролцогч талуудын харилцаа

М-Си-Эс Групп бизнесийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоог хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан бүх оролцогч талын эрх ашиг, тэдгээрийн идэвх санаачилга, харилцаа, хамтын оролцоог чухалчлан хамтран ажилладаг.

М-Си-Эс Групп оролцогч талуудтай олон суваг, механизмаар дамжуулан харилцаж, БОНЗ-ын тогтолцооны талаар гарсан санал, дүгнэлтэд суурилан үйл ажиллагаагаа тогтмол сайжруулж байна.



Оролцогч талууд	Харилцааны хэлбэр, механизмууд
Ажилтнууд	<ul style="list-style-type: none"> Сэтгэл ханамж, байгууллагын соёлын судалгаа Сургалт хөгжлийн хөтөлбөрүүд Салбар, үйл ажиллагааны чиглэлийн уулзалт Бүх ажилтны зөвлөгөөн Дотоод мэдээллийн сувгууд Спийк-Аут
Удирдлага, менежментийн баг	<ul style="list-style-type: none"> БОНЗ-ын хүрээнд удирдан чиглүүлэх, стратеги хэрэгжүүлэх, хяналт Улирлын болон жилийн тайлан Удирдах ажилтны зөвлөгөөн БОНЗ ба тогтвортой хөгжлийн дотоод мэдээллийн суваг
Хөрөнгө оруулагчид	<ul style="list-style-type: none"> Удирдах зөвлөлийн хурал БОНЗ-ын гүйцэтгэл, тайлагнал БОНЗ-ын хорооны уулзалт
Нийлүүлэгчид	<ul style="list-style-type: none"> Худалдан авалтын систем Цахим хуудас, нийгмийн сүлжээ Санал асуулга, Спийк-Аут
Туслан гүйцэтгэгчид	<ul style="list-style-type: none"> Хамтын ажиллагаа, уулзалтууд Дотоод аудит Санал асуулга, Спийк-Аут
Хэрэглэгчид	<ul style="list-style-type: none"> Танилцуулга, мэдээллийн хуудас Санал асуулга Харилцагчийн харилцааны сувгууд Цахим хуудас, нийгмийн сүлжээ Спийк-Аут
Төрийн байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгж	<ul style="list-style-type: none"> Ил тод, нээлттэй тайлагнал Хөндлөнгийн болон дотоод аудит Салбарын уулзалт, хэлэлцүүлэг
Төрийн бус байгууллага	<ul style="list-style-type: none"> Сайн дурын үйл ажиллагаа Хамтын ажиллагаа, уулзалтууд Нийгмийн хариуцлага, тусламж дэмжлэг
Иргэд, олон нийт	<ul style="list-style-type: none"> Тогтвортой хөгжлийн тайлан Зорилтот төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан мэдлэг, мэдээлэл түгээх сургалт, уулзалт Олон нийт, нөлөөллийн бүсийн иргэдийн оролцоог хангасан уулзалт хэлэлцүүлэг Өргөдөл, санал хүсэлт авах, шийдвэрлэх тогтолцоо Цахим хуудас, нийгмийн сүлжээ

БАЙГАЛЬ ОРЧИН

Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хий	13
Эрчим хүчний менежмент	14
Тээвэр	15
Усны менежмент	16
Хог хаягдлын менежмент	17
Биологийн олон янз байдал	19

Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хий

2022 онд М-Си-Эс Кока-Кола, Анунгоо, Энержи Ресурс, Юнител, Тотал Дистрибушин болон Вэллбий компани хүлэмжийн хийн ялгарлаа тооцож, бууруулах арга хэмжээ авч ажиллалаа.

Тайлант онд нийт

676 мян.тн CO₂-экв

(түвшин 1 ба 2-ын хүрээнд) ялгаруулсан.

42

мян.тн CO₂-экв

Өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, худалдаа болон харилцаа холбооны чиглэлээр ажиллаж буй таван компани

634

мян.тн CO₂-экв

Энержи Ресурс компанийн үйл ажиллагааны хүрээнд

Зарим үйл ажиллагаанд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын арга зүйн тооцоолол хийсэн

4,800

тн CO₂-экв

М-Си-Эс Кока-Кола компани шингэрүүлсэн түлшээр ажилладаг дэвшилтэт уурын зуух ашиглан

952

тн CO₂-экв

Энержи Ресурс компани эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг ашиглан

5.8

мян.тн CO₂-экв
-аар бууруулсан байна.

Эрчим хүчний менежмент

● Эрчим хүчний хэмнэлт

М-Си-Эс Кока-Кола, Энержи Ресурс, Юнител, М-Си-Эс Интернэйшнл, Эрчим Сүлжээ, Интермед эмнэлэг, Шангри-Ла Улаанбаатар компаниуд эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд эрчим хүчний аудитыг хийж, менежментийн төлөвлөгөө боловсруулан холбогдох байгууллагад тайлагнадаг.



● Цэвэр эрчим хүчний эх үүсвэрүүд

Юнител Групп харилцаа холбооны цамхгуудаа сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэн, тайлант онд 196 нарны эрчим хүчээр ажилладаг цамхгаар нийт 2,418 МВт.ц эрчим хүч үйлдвэрлэн ашигласан ба одоогийн байдлаар 8.2 хувь нь сэргээгдэх эрчим хүчээр ажиллаж байна.



М-Си-Эс Кока-Кола компани шингэрүүлсэн хийн түлшээр ажилладаг, байгальд ээлтэй инженерингийн шийдэл бүхий зуух ашиглан 5.7 сая МЖ уурыг үйлдвэрлэж ашиглажээ.



Тээвэр

Тотал Дистрибушин компани түлшний шаталтаас үүсэх хийн ялгарлыг бууруулах зорилгоор Евро-5 шатахуунд шилжих туршилтын тээврийг Орхон, Дархан хотын чиглэлд эхлүүллээ. Түүнчлэн 2022 онд Евро-5 хөдөлгүүрт 33 автомашиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн түлшний хэмнэлтийн тооцооллыг хийж байна.

Тотал Дистрибушин болон М-Си-Эс Кока-Кола компаниуд 100 хувь цахилгаан сэрээт өргөгчийг ашиглаж байна.

100%

Эрчим Сүлжээ компани цахилгаан автомашин болон тэдгээрийг цэнэглэх станцуудыг байгуулах төслийг тайлант онд хэрэгжүүлж эхэлсэн.



Усны менежмент

М-Си-Эс Кока-Кола, М-Си-Эс Интернэйшнл, Энержи Ресурс компаниуд үйл ажиллагаанд ашигласан усаа үйлдвэрийн дэргэдэх ус цэвэршүүлэх байгууламжаар цэвэршүүлдэг.

- Тайлант онд М-Си-Эс Кока-Кола компани 298 мян.тн усыг цэвэршүүлсэн. Үүнээс 11 мян.тн усыг нийслэлийн зам болон ногоон байгууламжийн усалгаанд ашигласан байна.
- М-Си-Эс Интернэйшнл компани үйлдвэрлэлийн хаягдал 13 мян.тн усыг дахин цэвэршүүлсэн. Түүнчлэн Ухаа Худагийн цахилгаан станцын технологийн хаягдал усыг шинжилж, 52 мян.тн усыг зам, мод усалгаанд дахин ашигласан.
- Энержи Ресурс компани ахуйн хэрэглээний 134 мян.тн усыг цэвэршүүлсэн. Түүнчлэн 1 мян.тн дахин боловсруулсан усыг зам болон ногоон байгууламжийн усалгаанд, 30 мян.тн усыг замын тоосжилтыг дарахад ашиглажээ.




93 мян.тн ус

Нийт дахин ашигласан усны хэмжээ



М-Си-Эс Кока-Кола компани 1 л бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулдаг усны хэмжээгээ сүүлийн 10 жилд 29 хувиар бууруулж, 2.1 л болгоод байна.



Хог хаягдлын менежмент

- М-Си-Эс Групп үйл ажиллагаанаас үүсэх энгийн болон аюултай хог хаягдлыг зориулалтын дагуу боловсруулдаг.
 - ▶ Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний компаниудын үйл ажиллагаанаас үүссэн 488 тн энгийн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт, 412 тн хог хаягдлыг зориулалтын дагуу гэрээт байгууллагуудаар устгуулсан.
 - ▶ Уул уурхайн үйл ажиллагааны компаниудаас М-Си-Эс Интернэйшнл компани 686 м³ хатуу хог хаягдал, Энержи Ресурс компани 6,951 м³ хог хаягдлыг зориулалтын стандартын дагуу устгасан байна.
 - ▶ 2022 онд нийт 225 тн аюултай хог хаягдлыг зориулалтын дагуу устгуулсан, 730 м³ хаягдлыг шатаалтад, Тотал Дистрибушин, Энержи Ресурс компаниуд 315 тн автомашины тос, тосолгоо зэргийг зориулалтын саванд цуглуулан хадгалж, боловсруулах үйлдвэрт тус тус хүргүүлсэн.

- Хог хаягдлын дахин боловсруулалт

313 тн

М-Си-Эс Кока-Кола компани үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлын 53 хувийг дахин боловсруулсан.

183 кг

Вэллбий компани тайлант онд нийт борлуулсан бүтээгдэхүүний хөнгөн цагаан савлагааны 19 хувийг буцаан цуглуулж, дахин боловсруулаад байна.

403 м³

Энержи Ресурс компани үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлын 4.3 хувийг дахин боловсруулах үйлдвэрт боловсруулсан.



Хог хаягдлын менежмент



ХУВАНЦРЫН
ХАЯГДАЛГҮЙ
ДЭЛХИЙ

М-Си-Эс Кока-Кола компани үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, хэрэглээг багасгах, урт хугацаандаа бүтээгдэхүүний савлагааг 100 хувь дахин боловсруулах зорилгоор “Хуванцрын Хаягдалгүй Дэлхий” кампанит ажлыг эхлүүллээ.

М-Си-Эс Кока-Кола компани 330 мл, 500 мл савлагаатай Вонаqua усны савны жинг бууруулан, нийт 31 тн хуванцрын хэмнэлтийг бий болгосон.

Нийт борлуулсан ПЭТ савлагаатай бүтээгдэхүүний хуванцар савны 61 хувийг буцаан цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн.

Улаанбаатар хотын баруун болон зүүн бүсийн хүнсний дэлгүүрүүдэд “Хуванцар хүлээн авах цэг”-үүд ажиллуулж эхэллээ. Түүнчлэн орон нутагт хуванцар цуглуулах урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хуванцрын хаягдлыг төлбөртэй цуглуулах машиныг Улаанбаатар хотын 10 цэгт байршууллаа.

ПЭТ хуванцар сав цуглуулах кампанит ажилд Тотал Дистрибушин компанитай хамтран ажиллаж, орон нутгаас хуванцрын хаягдлыг цуглуулан “Ти Эм Эл” компанийн дахин боловсруулах үйлдвэр рүү тээвэрлэж байна.

Биологийн олон янз байдал

- Энержи Ресурс, Юнител, Эрчим Сүлжээ компаниуд байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг үнэлэн менежментийн төлөвлөгөө боловсруулдаг. Үүний хүрээнд сөрөг нөлөөгүй байж, үүсэж болзошгүй эрсдэл, хохирлыг бууруулах арга хэмжээг авч, өртөж болзошгүй биологийн төрөл зүйлийн судалгаа, мониторингийг хийн хамгааллын менежментийг хэрэгжүүлэх, дүйцүүлэн хамгаалах зэрэг арга хэмжээг авч, нэгдсэн менежментийн төлөвлөгөөний дагуу хөтөлбөр болгон хэрэгжүүлж байна.

Биологийн төрөл, зүйлийн амьдрах орчныг сайжруулах

- ▶ Энержи Ресурс компани биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалахаар "Говь гурван сайханы байгалийн цогцолбор" газар дахь доройтсон экосистем бүхий 7 га талбайд зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулахаар нөхөн сэргээлт хийсэн. Мөн зэрлэг амьтдад ажиглалт хийх зорилгоор Хангинах ууланд автомат камер байрлуулжээ.
- ▶ Юнител Групп 2022 онд Өмнөговь, Говь-Алтай, Дундговь аймгуудад ховордсон амьтдад зориулан дөрвөн хөв цөөрөм нэмж байгуулжээ. Өнөөдрийн байдлаар нийт долоон байршилд зэрлэг амьтдад ундны усны хэрэгцээг хангах зорилготой хөв, цөөрмийг байгуулаад байна.




Шувууд, зэрлэг амьтдын судалгаа, ажиглалт, биологийн төрөл зүйлийг хамгаалах

- ▶ Цогтцэций суман дахь Энержи Ресурс компанийн байгуулсан ойн зурваст, "Тавантолгой" нисэх буудлын орчимд шувууны тандалт, судалгааг мэргэжлийн байгаль орчны байгууллагаар хийлгэж байна. Шувууны судалгааг мэргэжлийн арга зүйн дагуу хийж гүйцэтгэхэд 44 байршлаас 18 зүйлийн 853 бодгалийг бүртгэжээ.
- ▶ Юнител Групп Багахангай дүүрэгт амьдрах орчны доройтолд орсон махчин шувуудын тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор "Монголын шувуу судлалын нийгэмлэг ТББ"-тай хамтран шувууны амьдрах 30 оромжийг байгуулсан байна. 120-150 орчим махчин шувууны амьдрах орчныг бүрдүүлэх төлөвтэй байна.
- ▶ Эрчим Сүлжээ компани шувуудыг эрчим хүчний дамжуулах шугамын өндөр хүчдэлд кохиулах эрсдэлээс хамгаалах зорилгоор ажиглалт хийсний үр дүнд 336 ширхэг шувуу үргээгчийг байршуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллалаа.

НИЙГЭМ

Ажиллах орчин ба ажилтнууд	21
Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр	22
Сургалт, хөгжил, чадавх бэхжүүлэх	24
Сайн дурын үйл ажиллагааг дэмжих	27
Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй	28
Иргэд, олон нийт, нийгэмд чиглэсэн арга хэмжээ	29
Нийгмийн хариуцлага ба хамтын ажиллагаа	33

Ажиллах орчин ба ажилтнууд



2022

Үзүүлэлт

Хөнгөлөлт хангамжийн журмаар дамжуулан 2022 онд **9.1 тэрбум** төгрөгийг ажилтнуудад дэмжлэг үзүүлэхэд зориулжээ.

Нийт ажилтны тоо (тогтмол ажлын байр)

Нийт эмэгтэй ажилтны тоо (тогтмол ажлын байр)

Нийт ажилтны тоо (түр ажлын байр)

Нийт менежерийн тоо

Нийт эмэгтэй менежерийн тоо

Нийт удирдах түвшний менежерийн тоо

Нийт удирдах түвшний эмэгтэй менежерийн тоо

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо

Шууд бусаар бий болгож буй ажлын байрны тоо

4.3 / 5

Ажилтны сэтгэл ханамж
(Нийт ажилтны сэтгэл ханамжийн судалгаагаар)

Бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, оновчтой, үр ашигтай, олон талт хөдөлмөрийн харилцааг бий болгохоор зорьж байна. “Хөдөлмөрийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хүртээмжтэй, эрх тэгш, олон янзат байдал зэрэг БОНЗ-ын зарчмуудыг Группийн ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хөдөлмөр эрхлэлтийн бодлогуудад жендер болон эрх тэгш байдал, хүртээмжит байдал, олон янзат тусган хэрэгжүүлж байна.

Суурь зарчим:

- ▶ Жендер эрх тэгш байдлыг хангах,
- ▶ Хөдөлмөр эрхлэлтэд ээлтэй орчин бүрдүүлэх
- ▶ Ижил тэгш боломжийг бүрдүүлэх
- ▶ Үл ялгаварлан гадуурхах
- ▶ Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, ангид байх
- ▶ Дарамт, хүчирхийллээс ангид байх

Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр

Бүсийн оффис

М-Си-Эс Групп ажилтнууддаа хүртээмжтэй, уян хатан ажиллах орчныг бүрдүүлэн ажиллахыг зорьдог. Үүний хүрээнд Юнител Групп баруун, зүүн, өмнө ба хойд бүсийн дөрөв М-Си-Эс Кока-Кола компани баруун, зүүн, төвийн бүсийн гурван оффисыг шинээр байгуулан ажиллуулж эхэллээ.



Зүүн бүсийн
Distributed office

● БЗД, 3-р хороо, 12-р хороолол, VIP оффис 32А байр 2, 3-р давхар



Тохируулсан ажлын байрны үнэлгээ

Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд тохируулсан ажлын байрыг бүрдүүлэх, тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлон сайжруулах, ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ажиллах орчинд тохируулсан ажлын байрны үнэлгээ”-г М-Си-Эс Кока-Кола компанийн төв оффис, Юнител Группийн төв оффис, дата төв болон зүүн бүсийн оффист тус тус хийж, ажиллах орчныг сайжруулах арга хэмжээ авч байна.

Байгууллагын дэргэдэх цэцэрлэг

М-Си-Эс Групп ажиллах таатай, уян хатан орчныг бүрдүүлж, хүүхэд харах, асрах үйлчилгээ болон цэцэрлэгт хамруулах замаар хүүхдийн хөгжлийг дэмжих зорилготойгоор “Бага насны хүүхдийн цогц хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлж, байгууллагын дэргэдэх цэцэрлэгийг байгуулж байна.

Тайлант онд М-Си-Эс Кока-Кола компани 75 хүүхдийн багтаамжтай “Хаппи Кидс” цэцэрлэг, Интермед эмнэлэг 80 хүүхдийн багтаамжтай “Энхрий Үрс” цэцэрлэгийг тухайн компанийн оффисын ойролцоо байгууллаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжиж буй энэхүү арга хэмжээнд ажилтнуудын хүүхдүүдээс гадна тухайн дүүргийн хүүхдүүдийг мөн хамруулж байгаа юм.



Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр

Сургалт, мэдлэг ойлголт

- ▶ М-Си-Эс Группийн БОНЗ-ын бодлогын хүрээнд “Хүн бүрт ээлтэй ажлын байр” сэдэвт багц сургалтыг “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ-тай хамтран зохион байгуулж, М-Си-Эс Кока-Кола, Анунгоо, Юнител, Вэллбий компанийн менежментийн түвшний 79 ажилтныг хамрууллаа.

Сургалтаар компанийн бодлого, журам дахь хүний эрхийн болон олон янзат, тэгш хүртээмжтэй байдал, жендерийн мэдрэмжтэй ажлын байр зэрэг онол, практик ойлголтыг ажилтнуудад хүргэсэн юм.



- ▶ М-Си-Эс Проперти компани жендерийн тэнцвэртэй оролцоог хангах хүрээнд ажилтнууддаа ёс зүй, ажлын байрны дарамт, жендерт суурилсан хүчирхийлэл, хөдөлмөрийн мөлжлөг, хүүхдийн хөдөлмөрийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах талаар сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Тайлант онд 64 сургалтад 186 ажилтан хамрагдсан байна.

- ▶ Энержи Ресурс компани эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг дэмжиж, хүртээмжтэй ажлын байраар хангах зорилгоор хүнд машин, механизмын операторын мэргэжил олгох сургалтад хамруулдаг. Тайлант онд 18 эмэгтэйг энэхүү сургалтад хамруулж, ажлын байраар хангажээ.

Операторын сургалтыг хэрэгжүүлж эхэлснээс хойш нийт 174 хүн хамрагдсанаас 41 эмэгтэй оператор тус компанид үргэлжлүүлэн ажиллаж байна.



Сургалт, хөгжил, чадавх бэхжүүлэх

М-Си-Эс Групп тайлант онд ажилтнуудынхаа чадавхыг бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулахад нийт 933 сая төгрөг зориулжээ.

3,229

Нийт сургалтын тоо

345

М-Си-Эс Академийн сургалт

230

Компани доторх сургалт

2,654

Бусад сургалт

Сургалтад хамрагдсан ажилтны тоо

15,072



Сургалт, хөгжил, чадавх бэхжүүлэх

М-Си-Эс Академийн зохион байгуулсан сургалтын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 39 хувиар, сургалтад зарцуулсан нийт цаг 44 хувиар тус тус өссөн байна.

- М-Си-Эсийн зааварлагч багш нар**
 Шинэ менежерүүдэд тулгарч буй саад бэрхшээлийг даван туулах, тавьсан зорилгоо биелүүлэхэд нь туслах туршлага, мэдээлэл, мэдлэгийг солилцох зорилгоор "Коучинг" хөтөлбөрийг М-Си-Эс Группийн дунд түвшний удирдлагуудаас бүрдсэн зааварлагч багш нарын багийн хамт хэрэгжүүлж байна. Тайлант онд 11 коуч (зааварлагч багш нар), 72 шинэ менежерт "коучинг" сургалт хийсэн байна.
- Сургалт, хөгжил**
 М-Си-Эс Группийн компани тус бүрийн үйл ажиллагааны онцлогт тохируулсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, ажилтны хөгжлийн тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 15 компанийн 1,950 ажилтанд 410 цагийн сургалтыг зохион байгуулжээ.



Сургалт, хөгжил, чадавх бэхжүүлэх

Цалинтай дадлагажих хөтөлбөр

М-Си-Эс Групп өнгөрсөн жилүүдэд “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, 300 гаруй оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг олгож байсан бол 2022 оноос эхлэн оюутан залууст практикт суурилсан ажлын бодит туршлага хуримтлуулж, ажлын гарааны суурийг цогцоор нь зөв эхлүүлэх боломж олгохоор “MCS Internship” цалинтай дадлагажих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрт дотоод болон гадаадын 10 орчим их, дээд сургуулийн 63 оюутан хамрагдсан ба тэдгээрийн дийлэнх нь М-Си-Эс Группийн компаниудад үндсэн ажилтнаар үргэлжлүүлэн ажиллах санал авч, амжилттай ажиллаж байна.

16

Компани

9

Мэргэжлийн чиглэл

63

Хөтөлбөрт хамрагдсан оюутны тоо

42

Ажлын санал авсан



Сайн дурын үйл ажиллагааг дэмжих

- Бид ажил олгогчийн дэмжлэгтэйгээр сайн дурын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрийг (ESV) хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд сайн дурын үйл ажиллагаанд оролцож буй ажилтнуудад нэг өдрийн буюу найман цагийн цалинтай чөлөөг олгодог.

Тайлант онд М-Си-Эс Группийн нэг ажилтан дунджаар 3.8 цагийг байгаль орчин болон хандив тусламж, дэмжлэгийн чиглэлийн сайн дурын ажилд зарцуулсан байна. Тухайлбал:

- М-Си-Эс Группийн ажилтнууд Улаанбаатар хот болон орон нутгийн есөн байршилд, 8,000 гаруй мод суулгаж, арчилгаа, усалгааг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлжээ.
- Юнител Групп "Ногоон байгаасай" багц хөдөлгөөний хүрээнд 1,700 гаруй олон нийтийн сайн дурын ажилтантай хамтран Туул голын эрэг дагуух 52 км газрыг цэвэрлэж, 200 тн хаягдал цуглуулсан.
- Юнисервис Солюшн компани Нийслэлийн 62 дугаар цэцэрлэгийн гадна талбай, "Ид шидийн орон" цэцэрлэгийн гадна болон дотор талбайг иж бүрэн цэвэрлэжээ.

Түүнчлэн М-Си-Эс Группийн ажилтнууд сайн дураар нэгдэж, хандив тусламж, ажил үйлчилгээг орон нутаг, алслагдсан дүүргийн зорилтот бүлгүүдэд болон төрийн бус байгууллагын төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлдэг.




Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй

Үзүүлэлт	2021	2022
ХАБЭА сургалт, зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо (давхардсан тоогоор)	47,727	92,949
ХАБЭА сургалтад зарцуулсан нийт дүн	167 сая	279 сая
Группийн хэмжээнд ХАБЭА, БО-ы хүрээнд зарцуулсан нийт дүн	7 тэрбум	5 тэрбум
100 ажилтанд ногдох хугацаа алдсан гэмтлийн давтамж буюу LTIFR	0.21	0.11
100 ажилтанд ногдох ослын хүндрэлийн зэрэг буюу SR	3.08	2.98

Галын үзлэг

М-Си-Эс Групп эрсдэлийн менежментийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу галын аюулгүй байдлын үзлэгийг тогтмол хийж, нийт ажилтнууддаа урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах сургалт, сургуулилтыг тогтмол хийдэг. Галын үзлэгийг тайлант онд 17 компанийн 21 барилга, байгууламжид хийж, илэрсэн 195 зөрчлийг бүртгэж, тэдгээрийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.




Иргэд, олон нийт, нийгэмд чиглэсэн арга хэмжээ

Авто зам дагуух үйлчилгээний жишиг цогцолбор “Өртөө 240” төсөл

Бүс нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих зорилготой, олон улсын стандартад нийцсэн “Өртөө 240” цогцолбор нь дулаан алдагдал багатай, цахилгаан тасалдсан тохиолдолд ч ажиллах боломжтой нар ба хийн хосолсон эрчим хүчний эко шийдэлтэй байгууламж юм. Энэхүү жишиг өртөө нь орон нутгийн 10 иргэнийг ажлын байраар хангахаас гадна аялагчдад мэдээлэл өгөх буланг тохижуулснаараа онцлог юм.



Энержи Ресурс компани орон нутгийн хөгжлийг дэмжихээр орон нутгийн иргэдийн усан хангамж, малын усалгаа болон эрчим хүчийг цогцоор шийдэхээр зорьж ирсэн. Орон нутгийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд 21 төсөл хөтөлбөрийг тайлант онд хэрэгжүүлж, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрт нийт 21.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжийг олгосон байна.



Иргэд, олон нийт, нийгэмд чиглэсэн арга хэмжээ

Энержи Ресурс компани нийгэм, орон нутагт чиглэсэн, урт хугацааны үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрүүдийг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлж ирсэн.

- ▶ Өвс тэжээлийн тусламж - 2008 оноос хойш орон нутгийн малчид, Өмнөговь аймгийн сумдын фондод өвөл, хаврыг өнөтэй давахад зориулан өвс, тэжээлийн тусламжийг жил бүр олгож ирсэн. 2022 онд 8,000 боодол өвс, 45 тн тэжээлийг татан авч, нөлөөллийн бүсийн малчин өрхүүдэд хандивлажээ. Түүнчлэн “Байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах” хөтөлбөрийн хүрээнд зэрлэг ан амьтдад зориулан 230 боодол өвс тавьсан байна.
- ▶ Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах - Орон нутгийн малчдын хэрэгцээнд үндэслэн бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх зорилгоор 2012 оноос хойш ус хангамжийн системийн гол шугамаас мал усалгааны системийг ажиллуулж ирсэн. Цагаан-Овоо багийн малчид болон отрын малчдын хүсэлтээр ус хангамжийн гүний хоёр худагт мал усалгааны зориулалттай усны гаргалгаа, цорго байгуулснаар найман өрхийн 6,000 гаруй малыг ундны усаар хангаж, отор нүүдэл хийж яваа малчдад малаа услах боломжийг бүрдүүлсэн.
- ▶ Зорилтот бүлгийн айл өрхүүдэд дэмжлэг үзүүлэх - Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал, өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт орон нутгийн зорилтот бүлгийн айл өрхүүдэд хүнд туссан. Тэдгээр өрхийн амьжиргааг дэмжихээр Цогтцэций сумын зорилтот бүлгийн 200 өрхөд хүнсний багц бүхий хүмүүнлэгийн тусламжийг хүргэжээ.



Иргэд, олон нийт, нийгэмд чиглэсэн арга хэмжээ

▶ Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих

Орон нутгийн малчид, иргэдийн жижиг, дунд бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр”-ийг “Хас банк”-тай хамтран хэрэгжүүлж, 23 иргэнд нийт 225 сая төгрөгийн хүүгүй зээлийг тайлант онд олгожээ.

▶ Орон нутгийн боловсролыг дэмжих хөтөлбөр

Энержи Ресурс компани “Сураад” математикийн цахим хөтөлбөрийн хүрээнд Цогтцэций сумын ерөнхий боловсролын хоёр сургуулийн 555 хүүхдийг таван сарын хугацаанд онлайн хөтөлбөрт хамруулж, математикийн хичээлийн хоцрогдлыг арилгах, чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Хөдөө орон нутгийн сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээр Цогтцэций сумын 7 дугаар цэцэрлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулан 85 сая төгрөгийн тавилга, эд хогшил, тоглоом хэрэгслийг хандивласан. Тайлант онд тус цэцэрлэгийн бүх бүлэгт хэрэгцээтэй сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомыг худалдан авч хандивлажээ.



Иргэд, олон нийт, нийгэмд чиглэсэн арга хэмжээ

▶ “Ойн зурвас” төсөл

Энержи Ресурс компани Цогтцэций суманд байгуулсан “Ойн зурвас” төслийн хүрээнд 2011 оноос хойш 23 га талбай бүхий төгөл байгуулж, модны тоо болон төрөл зүйлийг нэмэгдүүлэхээр мод тарьж ирсэн. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тайлант онд ойн зурвасын хэмжээг 42 га талбайгаар өргөжүүлэн 93 мянган ширхэг мод сөөг нэмж тарьсан байна

▶ Газар тариалан эрхлэлтийг дэмжих төсөл

2022 онд Ойн зурвасын 5 га талбайд 57 өрх, нэг албан байгууллага тариалалт хийж, 20 орчим төрлийн төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн тариалалт хийн 95 тн ургац хураан авсан. Ногооны талбайн усалгаанд нийт 17,000 м³ ус зарцуулсан бөгөөд тариалангийн талбайд туслах ажилтныг таван сарын хугацаанд цалинжуулан ажиллууллаа. Мөн “Алтан намар-2022” ургацын баяр, үзэсгэлэн худалдааг Цогтцэций сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, 70 гаруй иргэн, аж ахуй нэгж оролцлоо.



Нийгмийн хариуцлага ба хамтын ажиллагаа

Боловсрол

М-Си-Эс Групп МУИС, ШУТИС, ХААИС, МГТИС болон СЭЗИС-тай мэдлэг, чадвар, туршлага солилцох, сургалт зохион байгуулах талаар хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд Тогтвортой хөгжил, БОНЗ зэрэг үндсэн чиглэлээр ажиллахаар тохиролцсон юм.



Интермед эмнэлэг “Оюутны Тэтгэлэгт Хөтөлбөр”-ийг хоёр дахь жилдээ зохион байгуулж, сувилагч, эх баригч, лабораторийн техникч, дүрс оношилгооны техникч мэргэжлээр бакалаврын түвшинд суралцаж буй төгсөх курсийн 10 оюутанд тэтгэлэг олголоо.

Тотал Дистрибьюшин компани нь сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн өөрийгөө илэрхийлэх боломжийг нэмэгдүүлэх, дэмжих, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүр “Миний мөрөөдөл” эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж ирсэн. Тайлант онд 13-21 насны 41 хүүхэд уг арга хэмжээнд оролцсон юм.



Нийгмийн хариуцлага ба хамтын ажиллагаа


Эрүүл мэнд

Веллбий компани Д витаминжуулах аяны хүрээнд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд эмчлүүлж буй эх, хүүхдүүд болон таван аймгийн 13 сумын эмнэлэг, Улаанбаатар хотын хоёр эмнэлэгт Д витамин хандивласан байна.

М-Си-Эс Эстэйтс компани Ээлтэй Ертөнц ТББ-тай хамтран, тархины саажилттай хүүхдүүдийг асрах, тэдний асран хамгаалагчдыг ажлын байраар хангах төслийг дэмжиж ирсэн. Үүний хүрээнд Вива Сити хотхонд байрлах 293 м² үйлчилгээний талбайг үнэ төлбөргүйгээр ашиглуулж, 50 гаруй тархины саажилттай хүүхдийг өдөр өнжүүлэх үйлчилгээнд хамруулж, тэдний асран хамгаалагчдыг хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж байна.

Дижитал шилжилт, хүртээмжийг бий болгох

Юнител Групп орон нутагт мэдээллийн технологийн хүртээмжийг нэмэгдүүлж дижитал боловсролыг олгох, мэдлэгээ хуваалцах тав тухтай орчныг бүрдүүлж өгөх зорилгоор “Unitel HUB” төвийг Дархан-Уул аймагт байгуулсан. Уг төв нь хүүхэд, залуус, өндөр настан зэрэг бүгдэд нээлттэй, хүртээмжтэй үйл ажиллагаа явуулахыг зорьдог бөгөөд тайлант онд 13 төрлийн нээлттэй сургалт зохион байгуулж, ойролцоогоор 1,600 иргэн үйлчлүүлжээ.



Нийгмийн хариуцлага ба хамтын ажиллагаа

Соёлын өв

М-Си-Эс Групп болон Монголын Урлагийн зөвлөлийн хамтран хэрэгжүүлж буй "Өв Эрдэнэ" тэтгэлэгт хөтөлбөр болон ХБНГУ-ын Соёлын өвийг хадгалан хамгаалах хөтөлбөрийн буцалтгүй тусламжаар анхны "Уран зураг сэргээн засварлах лаборатори"-ийг Монголын Уран Зургийн галерейн дэргэд амжилттай байгууллаа.

Энэхүү иж бүрэн лабораторийг олон улсын стандартад нийцсэн багаж хэрэгсэл, материал, тавилга, орчин үеийн технологиор иж бүрэн тохижуулсан ба галд өртсөн Монголын түүх, нийгмийн байдал, ахуйн болон байгалийн сэдэвт, хөрөг зэрэг 300 гаруй уран зургийг сэргээн засварлах, шинээр бүтээх боломж бүрдэж байна.



Нийгмийн хариуцлага ба хамтын ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш хүртээмжтэй байдлыг бий болгох, ажил эрхлэлтийг дэмжих зорилготой "Disability Expo 2022" арга хэмжээг Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хайнд Про байгууллагатай хамтран зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тохирох ажлын байранд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэг дороос хүргэх зорилготой юм.


Арга хэмжээг Тотал Дистрибьюшин, Юнител, М банк, Ашид Капитал ББСБ, М-Си-Эс Эстэйтс, Эрчим сүлжээ, Вэллбий, Юнисервис Солюшн, ДДэшТВ, Анунгоо, М-Си-Эс Кока Кола, М-Си-Эс Интернэйшнл зэрэг М-Си-Эс Группийн 12 компани дэмжин оролцсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байрны анкет бөглөх боломжийг бий болгосон юм.



ЗАСАГЛАЛ

Бүтэц тогтолцоо	38
БОНЗ-ын тогтолцоо	39

Бүтэц тогтолцоо



БОНЗ-ЫН ТОГТОЛЦОО

БОНЗ-ЫН ХОРОО

- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон мэдээлэл харилцаа холбооны компаниудад БОНЗ-ын бодлого батлагдсан.
- Тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулсан урт хугацааны зорилтуудаа тодорхойлж, гүйцэтгэлийн голлох индикаторыг компанийн үйл ажиллагаатай уялдуулж, хянадаг.
- БОНЗ-ын хороонд улирлын болон жилийн тайлагналын тогтолцоог бий болгосон бөгөөд 90 орчим санхүүгийн бус үзүүлэлтийг компани тус бүрийн онцлогт тохируулан тодорхойлж, улирлын тайланг тогтмол боловсруулж байна.
- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон мэдээлэл харилцаа холбооны компаниудад олон чиг үүргийг нэгтгэсэн БОНЗ хариуцсан дотоод баг томилогдон таван компанийн 35 ажилтан хавсран гүйцэтгэдэг.

АУДИТ БА ЭРСДЭЛИЙН ХОРОО


Эрсдэлийн удирдлагын менежмент

- ISO 31000:2018 стандартад суурилсан эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь бизнесийн салбарын онцлогоос үл хамааран бүх төрлийн эрсдэлийг удирдах нийтлэг хандлагыг бий болгох, үүний хүрээнд нарийвчилсан зохицуулалт бүхий эрсдэлийн менежментийн цогц тогтолцоог бий болгон ажиллаж байна.
- Эрсдэл аудитын хороонд тайлагналтын тогтолцоог бий болгож, 12 компани улирал тутам тайлагнадаг.
- Группийн хэмжээнд дөрвөн сургалтад 95 ажилтан хамрагдсан.
- Эрсдэл хариуцсан 16 ажилтан томилогдон ажиллаж байна.

Нийцлийн менежментийн тогтолцоо

- ISO 37301 стандартад суурилан нийцлийн менежментийн тогтолцоог бүрдүүлэн группийн хэмжээнд зургаан нийцэл хариуцсан алба, нэгж байгуулагдан ажиллаж байна.
- Аудит ба эрсдэлийн хороонд тайлагналтын тогтолцоог бүрдүүлсэн.
- Группийн хэмжээнд 15 компанийн 209 өргөтгөсөн менежментийн ажилтан нийцлийн сургалтад хамрагдсан.
- 27 нийцэл хариуцсан ажилтан ажиллаж байна.

ЁС ЗҮЙН ХОРОО




ЭДИЙН ЗАСАГ


Эдийн засагт оруулсан хувь нэмэр 41

Эдийн засагт оруулсан хувь нэмэр

- 2022 онд нийгэм, эдийн засагт оруулсан хувь нэмэр



- Дотоодын худалдан авалт



- Нийгмийн хариуцлага



- Нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 32 тэрбум төгрөг зарцуулж, 93 төсөл хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.
- Үүнээс агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулж 23 тэрбум төгрөгийн эрчим хүчний нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлсэн.



Товчилсон үгийн жагсаалт

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МГТИС	Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль
МУИС	Монгол Улсын их сургууль
ПЭТ	Полиэтилен терефталат
СЭЗИС	Санхүү эдийн засгийн их сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман Улс
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Нэгжийн тайлбар

Вт	Ватт
га	Арван мянган хавтгай дөрвөлжин метр
км	Километр
л	Литр
м ²	Хавтгай дөрвөлжин метр
м ³	Шоо метр
МВт.ц	Мегаватт цаг
МЖ	Мегажоуль
мл	Миллилитр
СО ₂	Нүүрстөрөгчийн давхар исэл
тн	Тонн
төг	Төгрөг
экв	Эквивалент



Дэлхийн хөгжлийг Монголд